



ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР

САНХҮҮГИЙН АУДИТЫН ТАЙЛАН

ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 330 ДУГААР АНГИЙН 2023 ОНЫ САНХҮҮГИЙН ТАЙЛАН,
ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛД ХИЙСЭН АУДИТЫН ТАЙЛАН

АУДИТЫН КОД: ДАА-2024/121/НА-СТА-ТШЗ

Энэхүү аудитын тайлантай холбоотой нэмэлт мэдээллийг
дараах хаягаар авна уу.



Дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр

Утас: 70373089 Цахим хаяг: munkhbayarsh@audit.gov.mn

Аудитын менежер У.Батсүрэн

Утас: 70373089 Цахим хаяг: batsurenu@audit.gov.mn

Ахлах аудитор С.Батцэцэг

Утас: 70373089 Цахим хаяг: battsetsegs@audit.gov.mn

Ахлах аудитор С.Санжаажав

Утас: 70373089 Цахим хаяг: sanjaajavs@audit.gov.mn

Дархан-Уул аймаг

2024 он

АГУУЛГА

1. ХАРААТ БУС АУДИТОРЫН ДҮГНЭЛТ	3
2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ.....	5
3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА	13
3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа	13
3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин	13
3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал	13
3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд...	14
3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв	14
4. АУДИТЫН ТАЙЛАН	17
4.1 Ерөнхий зүйл	17
4.2 Материаллаг байдал	17
4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт	17
4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал	17
4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт	18
4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт	18
4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал	18
5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ	19
6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ	20

Товчилсон үгийн жагсаалт

ААНОАТ	Аж ахуйн нэгжийн орлогын албан татвар
АДБОУС	Аудитын Дээд Байгууллагын Олон Улсын Стандарт
БОАЖЯ	Байгаль орчин аялал жуулчлалын яам
ГХБХБГ	Газрын харилцаа, барилга хот байгуулалтын газар
ЗХЖШ	Зэвсэгт хүчний жанжин штаб
УСНББОУС	Улсын Секторын Нягтлан Бодох Бүртгэлийн Олон Улсын Стандарт
ХХЕГ	Хил хамгаалах ерөнхий газар
ХХК	Хязгаарлагдмал хариуцлагатай компани



ЗЭВСЭГТ ХҮЧНИЙ 330 ДУГААР АНГИЙН
ЗАХИРАГЧ Н.БАТ-ЭРДЭНЭ ТАНАА

**ДАРХАН-УУЛ АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗАР**

Бурхантын гудамж-1, 14 дүгээр баг, Дархан сум,
Дархан-Уул аймаг, 45059,
Утас: 7037-3089, Факс: (976) 7037-3089
Цахим шуудан: darkhanuul@audit.gov.mn
Цахим хуудас: www.audit.mn

2024.02.19 № 4/03
танай _____-ны № _____-т

Өөрчлөлтгүй дүгнэлт

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.1, 8 дугаар зүйлийн 8.1, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.9.1-д заасны дагуу Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн байдал, санхүүгийн үр дүн, цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлт, мөнгөн гүйлгээний тайлан, тодруулгууд болон төсвийн гүйцэтгэлд аудит хийлээ.

Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартад нийцүүлэн бүх материаллаг зүйлсийн хувьд үнэн зөв толилуулсан байна.

Дүгнэлтийн үндэслэл

Төрийн аудитын байгууллага аудит хийхдээ Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт, түүнд нийцүүлэн Монгол Улсын Ерөнхий аудиторын баталсан журам, зааврын дагуу гүйцэтгэж, аудит хийгдэх байгууллагаас хараат бус, аудиторын ёс зүйн үүрэг хариуцлагыг биелүүлж ажилласан. Бидний цуглуулсан хангалттай бөгөөд зохистой аудитын нотолгоо нь дүгнэлт өгөх үндэслэл болно.

Асуудлыг онцолсон хэсэг

ЗХЖШ-ын 2023 оны 05 дугаар сарын 29-ны өдрийн А/240 дугаар тушаалаар “Оюутан-цэрэг” сургалтын цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтыг 2023 оны 06 дугаар сарын 15-ны өдрөөс 08 дугаар сарын 15-ны өдрүүдэд зохион байгуулсан байна. Үүнд Батлан хамгаалах яамнаас 72,923.8 мянган төгрөгийн санхүүжилт олгосныг нэмэлт санхүүжилтийн дансаар хүлээн авч зориулалтын дагуу бүрэн зарцуулжээ.

Аудитын гол асуудал

Монгол Улсын Засгийн Газрын 2022 оны 488, 2023 оны 06 дугаар сарын 21-ний өдрийн 241 дүгээр тогтоолоор төрийн албан хаагчдын цалин хөлсийг шинэчлэн тогтоожээ. Мөн Засгийн газрын 2023 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 52 дугаар тэмдэглэлээр цалингийн сангийн хэмнэлтээс ажилтны ажлын үр дүнг нь харгалзан үзэж нэг сарын үндсэн цалингийн 100 хүртэл хувиар тооцож урамшуулахаар шийдвэрлэсэн байна.

Бусад асуудлын хэсэг

Төсвийн шууд захирагч бусад мэдээлэлтэй холбоотой үүрэг хариуцлагыг хүлээнэ. Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2023 оны гүйцэтгэлийн төлөвлөгөөнд 117 арга хэмжээ төлөвлөж, гүйцэтгэлээр 116 арга хэмжээг хэрэгжүүлж, хэрэгжилтийг 97.43 хувиар тайлагнасан байна.

Санхүүгийн тайланд өгсөн бидний дүгнэлт бусад мэдээллийг хамраагүй болно.

009020021

Санхүүгийн тайланд төсвийн захирагчийн хүлээх үүрэг, хариуцлага

Төсвийн захирагч санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Төсвийн тухай хууль, Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль, Улсын секторын нягтлан бодох бүртгэлийн олон улсын стандартын дагуу үнэн зөв бэлтгэж толилуулах үүрэгтэй.

Санхүүгийн тайланг залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийлэлгүй бэлтгэхэд шаардлагатай гэж үзсэн дотоод хяналтыг тодорхойлж, хэрэгжүүлэх үүрэг хариуцлага хүлээнэ.

Төрийн аудитын байгууллагын үүрэг, хариуцлага

Төрийн аудитын байгууллага залилан эсвэл алдааны улмаас үүсэх материаллаг буруу илэрхийллээс санхүүгийн тайлан бүхэлдээ ангид эсэх талаарх үндэслэлтэй баталгаажуулалт олж авах, дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргах зорилготой.

Үндэслэлтэй баталгаажуулалт нь дээд түвшнийх боловч үнэмлэхүй түвшний баталгаажуулалт биш бөгөөд АДБОУС-ын дагуу хийсэн аудитаар бүх материаллаг буруу илэрхийлэл бүрийг илрүүлнэ гэсэн баталгаа болохгүй юм.

Буруу илэрхийлэл нь залилан эсвэл алдаанаас үүсэж болох бөгөөд дангаараа эсвэл нийлээд уг санхүүгийн тайланд үндэслэн гарах хэрэглэгчдийн эдийн засгийн шийдвэрт нөлөөлөх үндэслэлтэй байвал материаллаг гэж үздэг.

ДАРГА, ТЭРГҮҮЛЭХ АУДИТОР

Ш.МӨНХБАЯР

A handwritten signature in black ink is written over a red rectangular official stamp. The stamp contains the Mongolian text "Аудитын байгууллага" (Audit Agency) at the top and "9022899" and "451714382" at the bottom. The signature is a stylized, cursive script.

2. АУДИТ ХИЙСЭН САНХҮҮГИЙН ТАЙЛАН, ТӨСВИЙН ГҮЙЦЭТГЭЛ

2.1 Аудит хийсэн санхүүгийн байдлын тайлан

Дансны код	Балансын үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл
1	ЭРГЭЛТИЙН ХӨРӨНГИЙН ДҮН	1,922,569,020.15	1,731,369,400.60
31	МӨНГӨН ХӨРӨНГӨ	-	-
35	БАРАА МАТЕРИАЛ	1,916,169,020.15	1,724,969,400.60
351	Түүхий эд материал	1,503,547,155.48	1,257,104,101.78
35110	Тусгай зориулалттай материал	1,493,285,684.66	1,246,382,185.46
35130	Эм боох материал	10,261,470.82	10,721,916.32
35200	Дуусаагүй үйлдвэрлэл	2,248,500.00	2,442,100.00
35300	Бэлэн бүтээгдэхүүн	30,190,557.00	47,255,578.21
354	Хангамжийн материал	333,239,207.67	391,134,020.61
35410	Бичиг хэргийн материал	4,798,366.00	7,233,679.05
35420	Аж ахуйн материал	59,968,383.00	67,516,768.00
35430	Сэлбэг хэрэгсэл	30,997,273.30	60,788,178.43
35440	Түлш, шатах тослох материал	27,355,496.96	25,425,215.44
35450	Барилгын засварын материал	495,000.00	6,556,000.00
35460	Хүнсний материал	190,123,713.41	200,309,354.69
35470	Бусад хангамжийн материал	19,500,975.00	23,304,825.00
35600	Мал амьтад	46,943,600.00	27,033,600.00
36	НӨӨЦИЙН БАРАА	6,400,000.00	6,400,000.00
36700	Бусад санхүүгийн хөрөнгө /ТӨҮГ/	6,400,000.00	6,400,000.00
2	ЭРГЭЛТИЙН БУС ХӨРӨНГИЙН ДҮН	25,907,626,646.81	25,430,097,981.07
39	ҮНДСЭН ХӨРӨНГӨ	25,907,626,646.81	25,430,097,981.07
392	Биет хөрөнгө	22,181,658,646.81	21,704,129,981.07
39201	Барилга, байгууламж, орон сууц	6,761,720,981.62	6,761,720,981.62
39202	Хуримтлагдсан элэгдэл	(1,188,014,238.72)	(1,483,022,185.28)
39203	Авто-тээврийн хэрэгсэл	1,070,629,215.20	999,463,325.20
39204	Хуримтлагдсан элэгдэл	(887,465,596.60)	(881,073,426.36)
39205	Машин тоног төхөөрөмж (компьютер)	1,253,283,606.30	1,251,665,573.80
39206	Хуримтлагдсан элэгдэл	(1,218,037,108.94)	(1,229,622,075.86)
39211	Батлан хамгаалах, цэргийн зориулалттай тоног төхөөрөмж	16,395,224,819.71	16,290,630,819.71
39212	Хуримтлагдсан элэгдэл	(5,683,031.76)	(5,633,031.76)
393	Биет бус хөрөнгө	3,725,968,000.00	3,725,968,000.00
39303	Бусад биет бус хөрөнгө	3,725,968,000.00	3,725,968,000.00
3	НИЙТ ХӨРӨНГИЙН ДҮН III=I+II	27,830,195,666.96	27,161,467,381.67
4	НИЙТ ӨР ТӨЛБӨР	804,797.00	-
41	БОГИНО ХУГАЦААТ ӨР ТӨЛБӨР	804,797.00	-
413	Өглөг	804,797.00	-
41320	Бараа үйлчилгээний зардлын өглөг	804,797.00	-
5	ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН	27,829,390,869.96	27,161,467,381.67
51	Засгийн газрын хувь оролцоо	27,829,390,869.96	27,161,467,381.67
511	Засгийн газрын оруулсан капитал /Засгийн газрын сан/ орон нутгийн сан	20,981,897,481.12	20,981,897,481.12
51101	Өмч: - төрийн	20,981,897,481.12	20,981,897,481.12
512	Хуримтлагдсан үр дүн	1,711,245,715.85	1,043,410,485.04
51210	Өмнөх үеийн үр дүн	1,711,245,715.85	1,711,333,973.33
51220	Тайлант үеийн үр дүн	-	(667,923,488.29)
51300	Хөрөнгийн дахин үнэлгээний зөрүү	5,136,247,672.99	5,136,159,415.51
6	ӨР ТӨЛБӨР, ЦЭВЭР ХӨРӨНГӨ ӨМЧИЙН ДҮН VI=IV+V	27,830,195,666.96	27,161,467,381.67

2.2 Аудит хийсэн санхүүгийн үр дүнгийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ОРЛОГЫН ДҮН (I)	6,377,486,683.38	8,111,651,895.46
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	407,124,874.38	359,373,652.46
120	Нийтлэг татварын бус орлого	407,124,874.38	359,373,652.46
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	279,686,200.25	290,218,983.58
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,523,709.76	25,067,122.00
1200045	Үнэ төлбөргүй хүлээн авсан орлого	269,162,490.49	265,151,861.58
120009	Бусад орлого	127,438,674.13	69,154,668.88
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,970,361,809.00	7,752,278,243.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,891,500,161.00	7,647,758,908.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,891,500,161.00	7,647,758,908.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,861,648.00	104,519,335.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,977,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	72,923,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,884,648.00	31,595,546.00
2	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЗАРДЛЫН ДҮН	6,998,855,389.80	8,674,502,863.75
21	УРСГАЛ ЗАРДАЛ	6,998,855,389.80	8,674,502,863.75
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	6,724,948,308.04	8,548,878,265.75
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,154,153,244.00	7,013,937,835.00
210101	Үндсэн цалин	3,258,260,468.00	4,508,660,457.00
210102	Нэмэгдэл	1,848,219,561.00	2,405,357,428.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,711,800.00	39,937,800.00
210104	Урамшуулал	29,961,415.00	59,982,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,958,631.00	191,541,919.00
210201	Тэтгэврийн даатгал	37,601,651.00	42,012,479.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,423,724.00	4,942,644.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,532,259.00	3,940,916.00
210204	Ажилгүйдлийн даатгал	858,566.00	942,798.00
210205	Эрүүл мэндийн даатгал	102,542,431.00	139,703,082.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	113,842,617.00	144,066,768.00
210301	Гэрэл, цахилгаан	40,979,046.00	43,236,965.00
210302	Түлш, халаалт	65,047,219.00	91,317,027.00
210303	Цэвэр, бохир ус	7,816,352.00	9,512,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	35,585,723.07	87,585,458.89
210401	Бичиг хэрэг	835,288.00	2,859,943.60
210402	Тээвэр, шатахуун	31,500,453.47	68,989,312.52
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	43,559.60	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	120,000.00	200,000.00
210407	Аж ахуйн материал худалдан авах зардал	1,158,980.00	3,549,224.00
210408	Бараа материал акталсны зардал	1,927,442.00	11,986,978.77
2105	Нормативт зардал	278,044,103.92	341,861,640.52
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	5,601,688.20	7,480,415.50
210502	Хоол, хүнс	195,970,474.50	237,078,040.03
210503	Нормын хувцас, зөөлөн эдлэл	76,471,941.22	97,303,184.99
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	82,828,091.79	22,073,500.00
210604	Урсгал засвар	82,828,091.79	22,073,500.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	200,000.00

210702	Дотоод албан томилолт	800,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,111,997.00	7,652,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,111,997.00	7,652,895.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	856,623,900.26	739,958,249.34
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	100,529,768.00	57,512,183.80
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	117,057,830.20	309,287,999.80
210903	Үндсэн хөрөнгийн элэгдэл, хорогдол	639,036,302.06	373,158,065.74
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	273,907,081.76	125,624,598.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	271,176,294.00	121,752,311.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	240,838,462.00	83,166,915.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,337,832.00	38,585,396.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,730,787.76	3,872,287.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,730,787.76	3,872,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ҮР ДҮН (3)=(1)-(2)	(621,368,706.42)	(562,850,968.29)
225	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ЗАРДЛЫН ДҮН	81,121,040.00	105,072,520.00
225001	Үндсэн хөрөнгө худалдсаны гарз	81,121,040.00	104,940,600.00
225005	Үнэ төлбөргүй гарсан зардал	-	131,920.00
4	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ БУС ҮР ДҮН (4)=(145-225)	(81,121,040.00)	(105,072,520.00)
5	НИЙТ ҮР ДҮН (5)=(3)+(4)	(702,489,746.42)	(667,923,488.29)

2.3 Аудит хийсэн мөнгөн гүйлгээний тайлан

Дансны код	Үзүүлэлт	Өмнөх оны гүйцэтгэл	Тайлант оны гүйцэтгэл
1	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (1)	5,980,885,518.76	7,777,345,365.00
12	ТАТВАРЫН БУС ОРЛОГО	10,523,709.76	25,067,122.00
120	Нийтлэг татварын бус орлого	10,523,709.76	25,067,122.00
120004	Төсөв байгууллагын өөрийн орлого	10,523,709.76	25,067,122.00
1200042	Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	10,523,709.76	25,067,122.00
13	ТУСЛАМЖ, САНХҮҮЖИЛТИЙН ОРЛОГО	5,970,361,809.00	7,752,278,243.00
1310	Улсын төвлөрсөн төсвөөс	5,891,500,161.00	7,647,758,908.00
131001	Урсгал үйл ажиллагааны санхүүжилт	5,891,500,161.00	7,647,758,908.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	78,861,648.00	104,519,335.00
131103	ЗГНХ,ЗДНХөрөнгө,түүнтэй адилтгах ангилагдаагүй нөөц хөрөнгөөс тухайн төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	19,977,000.00	-
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	-	72,923,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	58,884,648.00	31,595,546.00
2	НИЙТ ЗАРЛАГА ба ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН (2)	5,980,885,518.76	7,777,345,365.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	5,980,885,518.76	7,777,345,365.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	5,706,978,437.00	7,651,720,767.00
2101	Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	5,154,153,244.00	7,013,937,835.00
210101	Үндсэн цалин	3,255,813,401.00	4,508,660,457.00
210102	Нэмэгдэл	1,847,407,798.00	2,405,357,428.00
210103	Унаа хоолны хөнгөлөлт	17,711,800.00	39,937,800.00
210104	Урамшуулал	33,220,245.00	59,982,150.00
2102	Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	148,958,631.00	191,541,919.00
210201	Тэтгэврийн даатгал	37,601,650.00	42,012,480.00
210202	Тэтгэмжийн даатгал	4,423,724.00	4,942,645.00
210203	ҮОМШӨ-ний даатгал	3,532,259.00	3,940,916.00
210204	Ажилгүйдлийн даатгал	858,566.00	942,796.00
210205	Эрүүл мэндийн даатгал	102,542,432.00	139,703,082.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	111,752,617.00	142,579,568.00
210301	Гэрэл, цахилгаан	40,979,046.00	43,236,965.00
210302	Түлш, халаалт	62,957,219.00	89,829,827.00
210303	Цэвэр, бохир ус	7,816,352.00	9,512,776.00
2104	Хангамж, бараа материалын зардал	25,134,620.00	57,106,157.00
210401	Бичиг хэрэг	350,000.00	1,560,000.00
210402	Тээвэр, шатахуун	22,477,500.00	53,092,357.00
210403	Шуудан, холбоо, интернэтийн төлбөр	87,120.00	-
210405	Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	420,000.00	200,000.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,800,000.00	2,253,800.00
2105	Нормативт зардал	187,317,677.00	215,661,293.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	6,449,994.00	4,207,261.00
210502	Хоол, хүнс	180,867,683.00	211,454,032.00

2106	Эд хогшил, урсгал засварын зардал	21,454,651.00	17,303,500.00
210604	Урсгал засвар	21,454,651.00	17,303,500.00
2107	Томилолт, зочны зардал	800,000.00	200,000.00
210702	Дотоод албан томилолт	800,000.00	200,000.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	54,111,997.00	7,652,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	54,111,997.00	7,652,895.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,295,000.00	5,737,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,295,000.00	3,537,600.00
210902	Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	-	2,200,000.00
213	УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	273,907,081.76	125,624,598.00
2132	Бусад урсгал шилжүүлэг	271,176,294.00	121,752,311.00
213207	Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	240,838,462.00	83,166,915.00
213209	Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	30,337,832.00	38,585,396.00
2133	Улсын төсвөөс олгосон санхүүжилт, шилжүүлэг	2,730,787.76	3,872,287.00
213303	Төвлөрүүлэх шилжүүлэг	2,730,787.76	3,872,287.00
3	ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (3)=(1)-(2)	=====	=====
	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
4	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ОРЛОГЫН ДҮН (4)	-	-
5	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН МӨНГӨН ЗАРДЛЫН ДҮН (5)	-	-
6	ХӨРӨНГӨ ОРУУЛАЛТЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (6)=(4)-(5)	=====	=====
	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
7	САНХҮҮГИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНЫ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ	=====	=====
8	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (8)=(3)+(6)+(7)	-	-
9	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-
10	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-

2.4 Аудит хийсэн цэвэр хөрөнгө/өмчийн өөрчлөлтийн тайлан

Код	Үзүүлэлт	Засгийн газрын оруулсан капитал	Дахин үнэлгээний нөөц	Хуримтлагдсан дүн	Засгийн газрын хувь оролцооний нийт дүн
C01	2022 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,247,672.99	2,413,735,462.27	28,531,880,616.38
C02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	-	-
C03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,247,672.99	2,413,735,462.27	28,531,880,616.38
C04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт	-	-	-	-
C05	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний бууралт	-	-	-	-
C06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
C07	Тайлант үеийн үр дүн	-	-	(702,489,746.42)	(702,489,746.42)
C08	2022 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,247,672.99	1,711,245,715.85	27,829,390,869.96
D01	2023 оны 01-р сарын 01-нээрх үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,247,672.99	1,711,245,715.85	27,829,390,869.96
D02	Нягтлан бодох бүртгэлийн бодлогын өөрчлөлт	-	-	88,257.48	88,257.48
D03	Дахин илэрхийлсэн үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,247,672.99	1,711,333,973.33	27,829,479,127.44
D04	Үндсэн хөрөнгийн дахин үнэлгээний өсөлт, бууралт	-	(88,257.48)	-	(88,257.48)
D05	Үндсэн хөрөнгийн өсөлт, бууралт	-	-	-	-
D06	Орлогын тайланд хүлээн зөвшөөрөөгүй олз, гарз	-	-	-	-
D07	Гадаад валютын хөрвүүлэлтийн зөрүү	-	-	-	-
D08	Тайлант үеийн үр дүн	-	-	(667,923,488.29)	(667,923,488.29)
D09	2023 оны 12-р сарын 31-нээрх үлдэгдэл	20,981,897,481.12	5,136,159,415.51	1,043,410,485.04	27,161,467,381.67

2.5 Аудит хийсэн төсвийн гүйцэтгэлийн тайлан

Үзүүлэлт	Тайлант оны		Зөрүү	Хувь
	Батлагдсан төлөвлөгөө	Гүйцэтгэл		
НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	7,668,953,700.00	7,668,953,743.00	43.00	100.0
УРСГАЛ ЗАРДАЛ	7,668,953,700.00	7,668,953,743.00	43.00	100.0
БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	7,547,201,400.00	7,547,201,432.00	32.00	100.0
Цалин хөлс болон нэмэгдэл урамшил	7,013,937,800.00	7,013,937,835.00	35.00	100.0
Үндсэн цалин	4,508,660,422.00	4,508,660,457.00	35.00	100.0
Нэмэгдэл	2,405,357,428.00	2,405,357,428.00	-	100.0
Унаа хоолны хөнгөлөлт	39,937,800.00	39,937,800.00	-	100.0
Урамшуулал	59,982,150.00	59,982,150.00	-	100.0
Ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэл	191,541,900.00	191,541,919.00	19.00	100.0
Тэтгэврийн даатгал	42,012,480.00	42,012,480.00	-	100.0
Тэтгэмжийн даатгал	4,942,645.00	4,942,645.00	-	100.0
ҮОМШӨ-ний даатгал	3,940,916.00	3,940,916.00	-	100.0
Ажилгүйдлийн даатгал	942,796.00	942,796.00	-	100.0
Эрүүл мэндийн даатгал	139,703,063.00	139,703,082.00	19.00	100.0
Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	134,579,600.00	134,579,568.00	(32.00)	100.0
Гэрэл, цахилгаан	43,237,000.00	43,236,965.00	(35.00)	100.0
Түлш, халаалт	81,829,800.00	81,829,827.00	27.00	100.0
Цэвэр, бохир ус	9,512,800.00	9,512,776.00	(24.00)	100.0
Хангамж, бараа материалын зардал	43,790,000.00	43,790,000.00	-	100.0
Бичиг хэрэг	550,000.00	550,000.00	-	100.0
Тээвэр, шатахуун	42,040,000.00	42,040,000.00	-	100.0
Хог хаягдал зайлуулах, хортон мэрэгчдийн устгал, ариутгал	200,000.00	200,000.00	-	100.0
Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,000,000.00	1,000,000.00	-	100.0
Нормативт зардал	160,952,100.00	160,952,110.00	10.00	100.0
Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	3,369,500.00	3,369,510.00	10.00	100.0
Хоол, хүнс	157,582,600.00	157,582,600.00	-	100.0
Томилолт, зочны зардал	200,000.00	200,000.00	-	100.0
Дотоод албан томилолт	200,000.00	200,000.00	-	100.0
Бараа үйлчилгээний бусад зардал	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
Хичээл үйлдвэрлэлийн дадлага хийх	2,200,000.00	2,200,000.00	-	100.0
УРСГАЛ ШИЛЖҮҮЛЭГ	121,752,300.00	121,752,311.00	11.00	100.0
Бусад урсгал шилжүүлэг	121,752,300.00	121,752,311.00	11.00	100.0
Тэтгэвэрт гарахад олгох нэг удаагийн мөнгөн тэтгэмж	83,166,900.00	83,166,915.00	15.00	100.0
Нэг удаагийн тэтгэмж, шагнал урамшуулал	38,585,400.00	38,585,396.00	(4.00)	100.0
ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	7,668,953,700.00	7,672,826,030.00	3,872,330.00	100.1
УЛСЫН ТӨСВӨӨС САНХҮҮЖИХ	7,647,758,900.00	7,647,758,908.00	8.00	100.0
Улсын төсвөөс санхүүжих	7,647,758,900.00	7,647,758,908.00	8.00	100.0
ТӨСӨВТ БАЙГУУЛЛАГЫН ҮЙЛ АЖИЛЛАГААНААС	21,194,800.00	25,067,122.00	3,872,322.00	118.3
Туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжих	21,194,800.00	25,067,122.00	3,872,322.00	118.3
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	-	-	-	-
Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	-	-	-	-

2.6 Аудит хийсэн нэмэлт төсвийн гүйцэтгэлийн тайлан

Дансны код	Үзүүлэлт	Гүйцэтгэл
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
I	НИЙТ ЗАРЛАГА БА ЦЭВЭР ЗЭЭЛИЙН ДҮН	104,519,335.00
21	УРСГАЛ ЗАРДАЛ	104,519,335.00
210	БАРАА, АЖИЛ ҮЙЛЧИЛГЭЭНИЙ ЗАРДАЛ	104,519,335.00
2103	Байр ашиглалттай холбоотой тогтмол зардал	8,000,000.00
210302	Түлш, халаалт	8,000,000.00
2104	Хангамж, бараа материалын зардал	13,316,157.00
210401	Бичиг хэрэг	1,010,000.00
210402	Тээвэр, шатахуун	11,052,357.00
210406	Бага үнэтэй, түргэн элэгдэх, ахуйн эд зүйлс	1,253,800.00
2105	Нормативт зардал	54,709,183.00
210501	Эм, бэлдмэл, эмнэлгийн хэрэгсэл	837,751.00
210502	Хоол, хүнс	53,871,432.00
2106	Эд хогшил, урсгал засварын зардал	17,303,500.00
210604	Урсгал засвар	17,303,500.00
2108	Бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний төлбөр, хураамж	7,652,895.00
210801	Бусдаар гүйцэтгүүлсэн бусад нийтлэг ажил үйлчилгээний төлбөр хураамж	7,652,895.00
2109	Бараа үйлчилгээний бусад зардал	3,537,600.00
210901	Бараа үйлчилгээний бусад зардал	3,537,600.00
II	ЗАРДЛЫГ САНХҮҮЖҮҮЛЭХ ЭХ ҮҮСВЭР	104,519,335.00
1311	Нэмэлт санхүүжилтийн орлого	104,519,335.00
131104	Дээд шатны төсвийн захирагчийн төсөвт тусгагдсан төсвөөс доод шатны төсвийн захирагчид хуваарилсан хөрөнгө	72,923,789.00
131105	Төсвийн байгууллагын үндсэн үйл ажиллагааны хүрээнд бий болсон нэмэлт орлого	31,595,546.00
IV	НИЙТ ЦЭВЭР МӨНГӨН ГҮЙЛГЭЭ (III)=(II)-(I)	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эхний үлдэгдэл	
	Мөнгө, түүнтэй адилтгах хөрөнгийн эцсийн үлдэгдэл	

3. САНХҮҮГИЙН ТАЙЛАНГИЙН ТОДРУУЛГА

3.1 Байгууллага, түүний үйл ажиллагаа

Зэвсэгт хүчний 330 дугаар анги нь Монгол Улсын тусгаар тогтнол, бүрэн эрхт байдал, нутаг дэвсгэрийн бүрэн бүтэн байдлыг гаднын зэвсэгт халдлага, түрэмгийллээс хамгаалахад улсын бэлэн байдлыг хангах, хамгаалах чиг үүрэг бүхий Зэвсэгт хүчний жанжин штабын харьяа байгууллага юм.

3.2 Байгууллагын гадаад, дотоод орчин

Тус байгууллага нь Монгол Улсын үндсэн хууль, Монгол Улсын батлан хамгаалах тухай хууль, Орон нутгийн хамгаалалтын тухай хууль, Зэвсэгт хүчний тухай хууль, Цэргийн албаны тухай хууль, Цэргийн албаны эрх зүйн байдлын тухай хууль, Цэргийн албан хаагчийн эд хөрөнгийн хариуцлагын тухай хууль, Цэргийн албан хаагчийн тэтгэвэр, тэтгэмжийн тухай хууль, Дайны байдлын тухай хууль, Төрийн болон албаны нууцын тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль Нягтлан бодох бүртгэлийн тухай хууль болон бусад эрхийн актыг үйл ажиллагаандаа мөрдөж байна.

Тайлант хугацаанд Зэвсэгт хүчний тухай хууль, Төрийн албаны тухай хууль, Төрийн хэмнэлтийн тухай хууль, Хөдөлмөрийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа ажил үйлчилгээ худалдан авах тухай хууль зэрэг үйл ажиллагаа, санхүү, нягтлан бодох бүртгэлд мөрддөг хууль тогтоомж болон бодлого чиглэлд өөрчлөлт орсон байна.

Төсвийн шууд захирагч зарлагын гүйлгээнд гарын үсэг зурснаар дотоод хяналтыг хэрэгжүүлж байгаа бол Зэвсэгт хүчний жанжин штабын хяналт шалгалт, үнэлгээний газраас дотоод хяналтыг хэрэгжүүлдэг байна. Иймд төлөвлөлтийн үе шатанд аудитад хамааралтай хяналтыг үр нөлөөтэй гэж тодорхойлоод гүйцэтгэх үе шатанд хяналтын сорил хэрэгжүүлэх шаардлагагүй гэж үзсэн болно.

3.3 Санхүүгийн тайлагналын үзэл баримтлал

Санхүүгийн тайланг бүх материаллаг зүйлсийн хувьд холбогдох санхүүгийн тайлагналын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн эсэх талаар аудитор дүгнэлтээ илэрхийлснээр санхүүгийн тайлангийн зорилтот хэрэглэгчдийн зүгээс үзүүлэх итгэл үнэмшлийн хэмжээг нэмэгдүүлэхэд санхүүгийн тайлангийн аудитын зорилго оршино.

Зэвсэгт хүчний 330 дугаар анги 2023 оны санхүүгийн тайлан дахь ажил гүйлгээг аккрузал сууриар хөтөлж, нийтлэг зорилготой, үнэн зөв толилуулгын үзэл баримтлалын дагуу бэлтгэсэн байна.

Байгууллагын мөрдөж буй Нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичгийг Батлан хамгаалахын сайдын 2018 оны А/162 дугаар тушаалаар баталж, 2020 онд нэмэлт өөрчлөлт орсон байх ба салбарын онцлог, санхүүгийн программтай нийцсэн байна.

3.4 Нягтлан бодох бүртгэлийн гол бодлого, толилуулгад гарсан өөрчлөлтүүд

Зэвсэгт хүчний 330 дугаар анги 2023 оны санхүүгийн тайлангаа Сангийн сайдын 2006 оны 388 дугаар тушаалаар баталсан “Төсөвт байгууллагад мөрдөх нягтлан бодох бүртгэлийн дансны заавар”-ын дагуу бэлтгэсэн байна.

Тайлант хугацаанд нягтлан бодох бүртгэлийн бодлогын баримт бичигт нэмэлт өөрчлөлт ороогүй.

Тайлант оны жилийн эцсийн санхүүгийн байдлын тайлангаарх нийт хөрөнгийн дүн өмнөх оноос 668,728.3 мянган төгрөгөөр буюу 2.4 хувиар буурсан байна.

Хүснэгт 1. Санхүүгийн байдлын тайлангийн үзүүлэлт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Эхний үлдэгдэл	Эцсийн үлдэгдэл	Өөрчлөлт
Б	1	2	3=2-1
Авлага	-	-	-
Бараа материал	1,916,169.0	1,724,969.4	(191,199.6)
Нөөцийн бараа	6,400.0	6,400.0	-
Үндсэн хөрөнгө	25,907,626.6	25,430,097.9	(477,528.7)
Нийт хөрөнгө	27,830,195.6	27,161,467.4	(668,728.3)
Өр төлбөр	804.7	-	(804.8)
Засгийн газрын хувь оролцоо /Эздийн өмч/	27,829,390.8	27,161,467.4	(667,923.5)
Өр төлбөр ба цэвэр хөрөнгө/өмчийн дүн	27,830,195.6	27,161,467.4	(668,728.3)

Тайлант онд төсвийн хөрөнгөөр 297,766.1 мянган төгрөгийн бараа материал худалдан авч, Зэвсэгт хүчний дугаар ангиудаас 264,712.0 мянган төгрөгийн цэргийн хувцас хэрэглэл, эм, эмнэлгийн хэрэгсэл, бэлэн бүтээгдэхүүн, туслах аж ахуйн болон бусад эх үүсвэрээс 112,428.9 мянга, нийт 674,907.0 мянган төгрөгийн бараа материалыг орлогод авч, 866,106.6 мянган төгрөгийн бараа материал зарцуулснаар бараа материалын үлдэгдэл оны эцэст буурсан байна. Бараа материалын дансны үлдэгдлийн 71.9 хувь буюу 1,246,382.2 мянган төгрөгийг тусгай зориулалтын материал байна.

Үндсэн хөрөнгө 477,528.7 мянган төгрөгөөр буурахад хуримтлагдсан элэгдлийн өсөлт голлон нөлөөлжээ. Тодруулбал тайлант онд Зэвсэгт хүчний 310 дугаар ангиас 825.0 мянган төгрөгийн махны машин, ЗХЖШ-ын даргын 2023 оны А/349 дугаар тушаалаар 130.0 мянга, нийт 955.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгийг үнэ төлбөргүй хүлээн авч, элэгдлээрээ анхны өртгөө бүрэн нөхсөн 65,340.6 мянган төгрөгийн машин тоног төхөөрөмжийг акталж, ЗХЖШ-ын даргын тушаалаар ХХЕГ-ийн харьяа дугаар ангиудад 13,000.0 мянга, Зэвсэгт хүчний дугаар ангиудад 26,400.0 мянга, нийт 39,600.0 мянган төгрөгийн үндсэн хөрөнгө шилжүүлж, 373,543.0 мянган төгрөгийн элэгдэл тооцож, зардлаар хүлээн зөвшөөрсөн байна.

Өмнөх онд “Шунхлай петролиум” ХХК-тай үүссэн шатахууны өглөгийг тайлант онд бүрэн барагдуулсан байна.

Засгийн газрын хувь оролцоо дансны үлдэгдэл 27,161,467.4 мянган төгрөг болж 667,923.5 мянган төгрөгөөр буурсан нь тайлант үеийн үр дүнтэй холбоотой байна.

3.5 Төсвийн төлөвлөлт, гүйцэтгэл, нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.1-д заасны дагуу төсвийг төлөвлөх, хэрэгжүүлэх, тайлагнахад эрх бүхий байгууллага, төсвийн захирагч нь тус хуулийн

5 дугаар зүйлийн 5.1-д заасан төсвийн зарчмыг мөрдлөг болгож, хэрэгжүүлэх үүрэгтэй.

3.5.1 Төсвийн төлөвлөлт

Тус байгууллагын 2023 оны төсвийн төсөлд зардлыг санхүүжүүлэх эх үүсвэрийг улсын төсвөөс 8,646,640.6 мянга, туслах үйл ажиллагааны орлогоос 20,000.0 мянга, нийт 8,666,640.6 мянган төгрөгийг бүрдүүлэхээр тооцон төлөвлөж дээд шатны төсвийн захирагчид хүргүүлжээ. Төсвийн төслийн саналаас 2,063,565.7 мянган төгрөгийг хасаж, 6,603,074.9 мянган төгрөгөөр баталсан байна. Тодруулбал өмнөх оны гүйцэтгэлд үндэслэн цалингийн зардлыг 187,055.3 мянга, ажил олгогчоос төлөх нийгмийн даатгалын шимтгэлийг 3,476.2 мянга, хангамж, бараа материалын зардлыг 174,681.8 мянга, нормативт зардлыг 955,575.7 мянга, эд хогшил, урсгал засварын зардлыг 573,651.3 мянга, томилолт, зочны зардлыг 2,992.0 мянга, бусдаар гүйцэтгүүлсэн ажил, үйлчилгээний хөлс, төлбөр хураамжийн зардлыг 9,479.8 мянга, бараа үйлчилгээний бусад зардлыг 16,146.0 мянга, бусад урсгал шилжүүлгийг 142,064.5 мянган төгрөгөөр тус тус бууруулж, байр ашиглалттай холбоотой тогтмол зардлыг 1,556.8 мянган төгрөгөөр нэмж баталжээ.

3.5.2 Төсвийн гүйцэтгэл

Тайлант онд батлагдсан төсвийг 1,065,878.8 мянган төгрөгөөр нэмэгдүүлж тодотгосон байна. Ингэхдээ Засгийн газрын тогтоолоор төрийн албан хаагчдын цалин нэмэгдсэнтэй холбоотой цалин, ажил олгогчоос нийгмийн даатгалд төлөх шимтгэлийн зардлыг 916,510.5 мянга, хангамж бараа материалын зардлыг 6,890.0 мянга, нормативт зардлыг 22,412.3 мянга, томилолт, зочны зардлыг 200.0 мянга, бусад урсгал шилжүүлэг буюу нэг удаагийн мөнгөн тэтгэмж, урамшууллын зардлыг 121,752.3 мянган төгрөгөөр тус тус нэмж, байр ашиглалтын тогтмол зардлыг 1,885.9 мянган төгрөгөөр бууруулсан байна.

Төсвийн захирагчийн хэрэгжүүлэх 1 хөтөлбөрийн 2 арга хэмжээг санхүүжүүлэхээр 7,647,758.9 мянган төгрөг буюу 99.7 хувийг улсын төсвөөс, 21,194.8 мянган төгрөг буюу 0.3 хувийг туслах үйл ажиллагааны орлогоос санхүүжүүлэхээр төлөвлөжээ.

Гүйцэтгэлээр улсын төсвөөс 7,647,758.9 мянган төгрөгийн санхүүжилт авч, туслах үйл ажиллагааны орлогоос 25,067.1 мянган төгрөг буюу төлөвлөгөөг 3,872.3 мянган төгрөгөөр давуулан биелүүлжээ. Төсвийн зарлагын гүйцэтгэл 7,668,953.7 мянган төгрөг буюу 100 хувьтай байна. Туслах үйл ажиллагааны орлогоос давж биелсэн 3,872.3 мянган төгрөгийг улсын төсөвт төвлөрүүлжээ.

Хүснэгт 2. Хөтөлбөр, арга хэмжээний төлөвлөгөө, гүйцэтгэл

/мянган төгрөгөөр/					
д/д	Хөтөлбөр, арга хэмжээ	Төлөвлөгөө	Гүйцэтгэл	Зөрүү	Биелэлт
А	70601-Зэвсэгт хүчний үйл ажиллагаа	7,668,953.7	7,668,953.7	-	100.0
1	80101"-Үндсэн үйл ажиллагааны зардал	7,547,201.4	7,547,201.4	-	100.0
2	"80802"- Ажил олгогчоос олгох тэтгэмж, урамшуулал, дэмжлэг	121,752.3	121,752.3	-	100.0

Батлагдсан төсөв, гүйцэтгэл, түүний хэтрэлт, хэмнэлтийг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.5-д харуулав.

3.5.3 Нэмэлт төсөв

Төсвийн тухай хуулийн 47 дугаар зүйлийн 47.2-т “нэмэлт төсөв, түүнтэй холбогдсон үйл ажиллагаа нь төсвийн нэгэн адил санхүүгийн болон төсвийн гүйцэтгэлийн тайлангийн бүрэлдэхүүн хэсэг байна” гэж заасны дагуу байгууллага нэмэлт санхүүжилтийн тайлан гаргах үүрэгтэй.

Тайлант онд нэмэлт санхүүжилтийн дансанд улсын төсөв, хувийн хэвшлээс 104,519.3 мянган төгрөгийн орлого бүрдүүлж, зориулалтын дагуу бүрэн зарцуулсан байна. Тодруулбал Батлан хамгаалах яамнаас “Оюутан-цэрэг” цэргийн мэргэжлийн бэлтгэл шатны сургалтын санхүүжилт 72,923.8 мянга, БОАЖЯ-аас 10,000.0 мянган төгрөгийн санхүүжилт, ЗХЖШ-ын даргын 2023 оны А/437, А/476 дугаар тушаалаар “Шийрийн Ундарга” ХХК, “Шинэ-Тариа” ХХК-тай байгуулсан гэрээт ажлын хөлс 21,595.5 мянган төгрөгийн орлого тус тус төвлөрсөн байна.

Нэмэлт төсвийн тайланг орлого, зардлын зүйл тус бүрээр энэ тайлангийн 2.6-д харуулав.

3.5.4 Төсөл хөтөлбөрийн үе шат, хүрэх үр дүн

Тайлант онд хэрэгжүүлсэн төсөл хөтөлбөр байхгүй.

Худалдан авах ажиллагааны гүйцэтгэл:

Тайлант онд хоол хүнсний материал худалдан авах 137,739.8 мянга, шатахуун тосолгооны материал худалдан авах 36,000.0 мянга, нийт 173,739.8 мянган төгрөгийн худалдан авах ажиллагаа зохион байгуулахаар төлөвлөгөөндөө тусгажээ. Гэвч оюутан цэргийн мэргэжлийн бэлтгэл хийх болсонтой холбогдуулан Батлан хамгаалах яамнаас тус цэргийн ангийн нэмэлт санхүүжилтийн дансанд 72,923.8 мянган төгрөг төвлөрснөөр худалдан авах ажиллагааны төлөвлөгөөний дүнг 246,663.6 мянган төгрөг болгож өөрчилсөн байна. Төлөвлөгөөний дагуу нээлттэй тендер 1, харьцуулалтын аргаар 2-ыг зохион байгуулсан байна.

4. АУДИТЫН ТАЙЛАН

4.1 Ерөнхий зүйл

Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.1-д “Төрийн аудитын байгууллага аудитын дүнд үндэслэн дүгнэлт, зөвлөмж бүхий аудитын тайлан гаргана” гэж заасны дагуу Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2023 оны 12 дугаар сарын 31-ний өдрөөрх санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлд хийсэн санхүүгийн тайлангийн аудитын тайланг танилцуулж байна.

Аудитын тайланд аудит хийгдэх байгууллага, түүний орчин, аудитад хамааралтай дотоод хяналт, нягтлан бодох бүртгэл, санхүүгийн тайлагналын үзэл баримтлал, аудитаар илрүүлсэн буруу илэрхийлэл, түүнийг шийдвэрлэсэн байдал, дараагийн аудитаар анхаарах асуудал болон аудиторын дүгнэлт, дүгнэлтийн үндэслэлийг хураангуйлан толилуулав.

Аудитыг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газрын ахлах аудитор С.Санжаажав гүйцэтгэж, хяналтыг ахлах аудитор С.Батцэцэг, аудитын менежер У.Батсүрэн, газрын дарга, тэргүүлэх аудитор Ш.Мөнхбаяр нар тус тус хэрэгжүүлсэн.

Зэвсэгт хүчний 330 дугаар ангийн 2023 оны санхүүгийн тайлан, төсвийн гүйцэтгэлийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 01 дүгээр сарын 22-ны өдрийн Н/15 дугаартай албан бичгээр ирүүлсэн байна.

4.2 Материаллаг байдал

Төлөвлөлтийн болон гүйцэтгэлийн материаллаг байдлыг АДБОУС 2320 дагуу тодорхойлсон бөгөөд материаллаг байдлын суурь үзүүлэлтээр 2023 оны батлагдсан төсвийг сонгож, материаллаг буруу илэрхийллийн эрсдэлийг дунд гэж үнэллээ.

Төлөвлөлтийн материаллаг байдлыг 2023 оны батлагдсан төсвийн 7,426,969.5 мянган төгрөгөөс 1 хувиар буюу 74,269.7 мянган төгрөгөөр тогтоосныг аудитын явцад дахин хянаж, шинэчлэн тогтоох шаардлагагүй гэж үзсэн.

4.3 Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэрэгжилт

Тайлант хугацаанд төрийн хэмнэлтийн тухай хуулийг мөрдөж ажилласан байна.

Өмнөх аудитаар өгсөн шийдвэрийн хэрэгжилт

Өмнөх аудитаар 29,763.1 мянган төгрөгийн зөрчилд 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

4.4 Санхүүгийн тайлангийн аудитаар шалгасан нийцлийн аудитын асуудал

АДБОУС 4000.16-д нийцлийн аудитыг санхүүгийн тайлангийн аудиттай хослуулан хийх тохиолдолд аудитор аль стандартыг дагаж мөрдөхийг үнэлэх, нийцлийн асуудлын талаарх дүгнэлтийг санхүүгийн тайланд өгөх аудиторын дүгнэлтээс тусад нь салгах хэрэгтэй гэж заасан байна.

4.4.1 Шилэн дансны тухай хуулийн хэрэгжилт

Шилэн дансны тухай хуулийн 6 дугаар зүйл, Засгийн газрын 2016 оны 29 дүгээр тогтоолоор баталсан "Шилэн дансны цахим хуудсанд тавих мэдээллийн агуулга, нийтлэг стандартыг тогтоох журам"-ын заалтыг хэрэгжүүлэх зорилгоор www.shilendans.gov.mn цахим хуудсанд холбогдох мэдээллийг оруулсан байх үүрэгтэй бөгөөд мэдээллийг бүрэн байршуулсан байв.

Нийцсэн бөгөөд зохистой байх батламж мэдэгдлийн түвшинд хэрэгжүүлсэн горим сорилд үндэслэн шилэн дансанд байршуулсан мэдээлэл нь шилэн дансны тухай хууль тогтоомжийн холбогдох заалттай нийцсэн байна гэж дүгнэлээ.

4.5 Завсрын аудитын үр дүн, өмнөх зөвлөмжийн хэрэгжилт

4.5.1 Завсрын аудитын талаар

Завсрын аудит хийгдээгүй болно.

4.5.2 Өмнөх аудитын мөрөөр авч хэрэгжүүлсэн арга хэмжээний үр дүн

Өмнөх аудитаар нийт 29,763.1 мянган төгрөгийн зөрчил илрүүлж, 2 зөвлөмж өгснийг бүрэн хэрэгжүүлж ажилласан байна.

Хүснэгт 4 Төлбөрийн акт, албан шаардлага, зөвлөмжийн хэрэгжилт

/мянган төгрөгөөр/

Үзүүлэлт	Өмнөх аудитын үзүүлэлт		Биелэлт		
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Хувь
Зөвлөмж	2	29,763.1	2	29,763.1	100
Нийт дүн	2	29,763.1	2	29,763.1	100

4.6 Дараагийн аудитаар анхаарах асуудал

Дараагийн аудитаар анхаарах асуудал байхгүй болно.

5. АУДИТЫН ИЛРҮҮЛЭЛТ

Аудитаар илэрсэн тус цэргийн ангийн эзэмшлийн 1,321.0 мкв талбайтай 1 газрыг бүртгэлд тусгаагүй зөрчилд¹ хөрөнгө орлогод авах тухай албан шаардлага хүргүүлээ.

5.1 Төлбөрийн акт

- Төлбөрийн акт тогтоох зөрчил илрээгүй болно.

5.2 Албан шаардлага

- Тус ангийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 1,321.0 мкв талбайтай 1 эзэмшлийн газар бүртгэлд тусгаагүй байсан нь Газрын тухай хуулийн 35 дугаар зүйлийн 35.3-д заасан үүрэг, Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 14 дүгээр зүйлийн 14.4.2-д “*бүх хөрөнгө, хөрөнгө оруулалт, авлагыг заавал бүртгэнэ*”, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.1-д “*Төрийн өмчийн эд хөрөнгийг Нягтлан бодох бүртгэлийн тухай хуулийн 7 дугаар зүйлд заасан журмын дагуу үнэлж бүртгэнэ*” гэж заасантай тус тус нийцээгүй тул албан шаардлага хүргүүлэв.

5.3 Зөвлөмж²

Зөвлөмж өгөх зөрчил илрээгүй болно.

Дээрх албан шаардлагын биелэлтийг Дархан-Уул аймаг дахь Төрийн аудитын газарт 2024 оны 08 дугаар сарын 30-ны өдрийн дотор ирүүлнэ үү.

Аудитын явцад бидэнтэй хамтран ажилласан холбогдох ажилтнуудад талархал илэрхийлье.

¹ Хүчин төгөлдөр үйлчилж буй хууль тогтоомжид харшлах байгууллага, түүний удирдлага, байгууллагад ажилладаг бусад хувь хүний санаатай болон санамсаргүй үйлдэл, эс үйлдэл.

² 20.5. Шалгаагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ.

6. АУДИТААР ИЛЭРСЭН БУРУУ ИЛЭРХИЙЛЛИЙН НЭГТГЭЛ

Санхүүгийн тайлангийн аудитын зөрчлийн нэгтгэл

Зөрчлийн товч утга	Нийт зөрчил		Төлбөрийн акт		Үүнээс				Хариуцлага тооцуулах албан шаардлага		Хууль, хяналтын байгууллагад шилжүүлсэн асуудал	
	Тоо	Дүн	Тоо	Дүн	Албан шаардлага		Зөвлөмж		Тоо	Албан тушаалтны тоо	Тоо	Дүн
					Тоо	Дүн	Тоо	Дүн				
Тус ангийн үндсэн хөрөнгийн дансанд бүртгэлтэй газрыг ГХБХБГ-аас авсан лавлагаатай тулган шалгахад 1,321.0 мкв талбайтай 1 эзэмшлийн газар бүртгэлд тусгаагүй байв	1	-			1	-						
Дүн	1	-			1	-						

/мянган төгрөгөөр/